



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/177

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмыг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн мөрдсүгэй.
3. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш ажилтан, Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтнийг журмыг хэрэгжүүлэх мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/, Тусгай хэрэгцээт боловсролын хэлтэс /Ч.Ганцэцэг/-т тус тус даалгасугай.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журмыг 2021-2022 оны хичээлийн жилээс үе шаттай хэрэгжүүлэхэд шаардлагатай бэлтгэл, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга, өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлэх, боловсролд бүрэн хамруулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаа, энэхүү тушаалаар батлагдсан журмыг хэрэгжилтийг хангахад шаардагдах орчин бүрдүүлэх, хүний нөөцийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.
6. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Г.Энхжаргал/-т даалгасугай.


САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142110630

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2021 оны 05 дугаар сарын 13-ний
өдрийн А/177 дугаар тушаалын хавсралт



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд /цаашид “хүүхэд” гэх/-ийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулахтай холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”, “Хүүхдийн эрхийн конвенц”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”, “Боловсролын тухай хууль”, “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч, хөгжих эрхийн талаар тусгасан заалтыг удирдлага болгоно.

1.3. Бага насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ /цэцэрлэг/-д тэгш хамруулахад хүүхдийн суралцах, хөгжих эрхийг хүндэтгэх, тэдний эрүүл мэндийн байдал, онцлог хэрэгцээнд нийцсэн, ялгаварлан гадуурхалтаас ангид, хүртээмжтэй, нээлттэй байх, тэгш боломж олгох, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоог хангах зарчим баримтална.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1. Хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах ажлыг тухайн орон нутгийн захиргааны байгууллага, хүүхдийн цэцэрлэг хамтран зохион байгуулна.

2.2. Орон нутгийн захиргааны байгууллага /Засаг даргын тамгын газар/ хүн амын статистик мэдээлэлд үндэслэн аймаг/дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын болон эрүүл мэндийн байгууллагын оношилгоонд хамруулах шаардлагатай 3-5 настай хүүхдийн судалгааг гаргаж, жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор оношлуулан дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулна..

2.3. Хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулахад холбогдох талуудад дэмжлэг тусалцаа үзүүлэх үүрэг бүхий “Дэмжлэгийн баг”-ийг тухайн цэцэрлэгийн арга зүйч, багш, эмч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл, тусгай хэрэгцээт боловсролын багш, баг, хорооны нийгмийн ажилтныг оролцуулан цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар байгуулж, ажиллуулна.

2.4. Энэ журмын 2.3-т заасан “Дэмжлэгийн баг” нь жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх бөгөөд төлөвлөгөөнд дараах ажлыг тусган хэрэгжүүлнэ.

2.4.1. энэхүү журмын 2.2-д заасан комиссын дүгнэлтийг үндэслэн, хөгжлийн бэрхшээлтэй гэж тогтоогдсон хүүхдийн эрүүл мэндийн байдлыг харгалзан боловсролын үйлчилгээнд хамруулах арга, хэлбэрийг тогтооно.

2.4.2. эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдээ оношлуулах, боловсролын үйлчилгээнд хамруулах, гэр бүлийн орчинд хүүхдийнхээ хөгжлийг дэмжих чиглэлээр заавар зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулах

2.5. Дэмжлэгийн баг төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, цэцэрлэгийн эрхлэгчид тайлагнана.

2.6. Цэцэрлэгийн эрхлэгч Дэмжлэгийн багийн жилийн эцсийн тайланг дүгнэн Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хүргүүлнэ.

2.7. Хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын талаарх мэдээллийг Боловсролын салбарын мэдээллийн системд цэцэрлэгийн арга зүйч/эрхлэгч хариуцан хугацаанд нь үнэн зөв бүртгэх, баталгаажуулах ажлыг зохион байгуулна.

2.8. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь Дэмжлэгийн баг болон цэцэрлэгийн багш, ажилтныг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

Гурав. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа

3.1. Цэцэрлэг нь энэ журмын 2.2-т заасан дүгнэлтэд үндэслэн хамран сургах тойргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээ, эрүүл мэндийн байдлаас хамааруулан, эцэг эх, асран хамгаалагчтай зөвшилцөн үндсэн болон хувилбарт сургалтад хамруулах талаар гэрээ байгуулна.

3.2. Цэцэрлэг нь хүүхдийг сурч хөгжих онцлог, эрүүл мэндийн байдал, дасан зохицох явц, хэрэгцээг харгалзан сургалтын болон хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд хамруулна.

3.3. Хүүхдийг цэцэрлэгийн орчинд дасан зохицоход туслах, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр багш дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

3.3.1. хүүхдийн хөгжлийн түвшнийг үнэлж, хэрэгцээг тодорхойлох;

3.3.2. хөгжлийн түвшин, онцлог, хэрэгцээнд үндэслэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хөгжлийн ахиц, өөрчлөлтийг үнэлэх;

3.3.3. хүүхдийн өөртөө үйлчлэх, хөгжих, сурах явцад тохиолдох бэрхшээлийг даван туулахад туслах;

3.3.4. хүүхдийн хөгжилд гарч буй өөрчлөлтийн талаар тэмдэглэл хөтөлж, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой улирал тутамд дүгнэлт гаргах;

3.3.5. хэрэгжүүлсэн ганцаарчилсан сургалт, хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар бусад багш нарын оролцоотой хэлэлцэж, харилцан туршлага солилцох;

3.3.6. хүүхэдтэйгээ ажиллах, хөгжлийг нь дэмжих чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөн туслах, хамтран ажиллах;

3.3.7. тухайн хүүхдийн талаар энэ журмын 2.4.1-д заасан комиссын шийдвэрийг үндэслэн хүүхэд хүлээн авах, тарах, хооллох, нойрсох үйл ажиллагааны хугацааг уян хатан тогтоож, өдрийн дэглэмийг ялгаатай байдлаар төлөвлөж мөрдөх;

3.3.8. хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг бүх хүүхэд бүрэн оролцох боломжтой байхаар төлөвлөн зохион байгуулах;

3.3.9. тухайн хүүхдийг сургалт, үйл ажиллагаанд тэгш оролцох боломжоор хангах, тохирох хэрэглэгдэхүүн бэлтгэн хэрэглэх.

3.4. Цэцэрлэгийн багш, ажилтан нь хариуцсан ажлын чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах онол, арга зүйн мэдлэг, чадвар, хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн сургалт, хөгжлийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах, хөгжлийн ахиц өөрчлөлтийг үнэлэх арга зүйг эзэмшсэн байна.

3.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш, ажилтныг энэ журмын 3.4-д заасан арга зүйгээр хангах ажлыг цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага хамтран зохион байгуулна.

3.6. Энэхүү журмын 4.2-д заасан танхимд ажиллах багш, ажилтан нь засан сайжруулах, сэргээн засах чиглэлээр мэргэшсэн байна.

3.7. Цэцэрлэгийн туслах багш нь хүүхдийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн өөртөө үйлчлэх энгийн чадвар, дадал эзэмшүүлэх, асрах үйлчилгээ үзүүлэх сургалтад хамрагдсан байна.

Дөрөв. Сургалтын орчин бүрдүүлэх

4.1. Цэцэрлэгийн удирдлага нь сургалтын хүртээмжтэй орчин бүрдүүлэх чиглэлээр дараах ажлыг зохион байгуулна.

4.1.1. цэцэрлэгийн барилга байгууламж, анги танхим, тоглоомын талбай, ариун цэврийн өрөөнд саадгүй нэвтрэх түгээмэл загвар бүхий тэгш, хүртээмжтэй, аюулгүй орчныг бүрдүүлэх;

4.1.2. хүүхдийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн холбогдох дүрэм, журмын дагуу сургалтын тохирох хэрэглэгдэхүүн, тоглоом, ном, гарын авлагаар хангах;

4.1.3. багш, ажилтан, эцэг эх асран хамгаалагчдад хүүхдийн болон эцэг эх, асран хамгаалагчийн онцлог, ялгаатай хэрэгцээний талаар нэгдсэн ойлголт, тэдэнтэй ажиллах заавар зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;

4.2. Цэцэрлэг нь хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн дэмжих үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий танхимтай байж болно.

4.3. Дэмжлэгийн баг нь энэ журмын 4.1-д заасан орчин бүрдүүлэхэд чиглэлээр орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллана.

4.4. Энэ журмын 4.1-д заасан орчин бүрдүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, иргэн, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, олон нийтийг татан оролцуулж болно.

Тав. Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах

5.1. Цэцэрлэгийн удирдлага дараах арга хэмжээг эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой хэрэгжүүлнэ.

5.1.1. хүүхдийн хөгжлийг дэмжих ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой боловсруулж, хэрэгжүүлэх;

5.1.2. эцэг эх, асран хамгаалагчийг зөвлөгөө, мэдээлэл, арга зүйгээр хангах, холбогдох үйл ажиллагаанд татан оролцуулах, харилцан туршлага солилцох, санал бодлоо илэрхийлэх боломжоор хангах.

5.2. Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийнхээ хөгжлийг дэмжих, сургалтын орчин бүрдүүлэх, шаардлагатай үед багшид туслах үүрэг хүлээнэ.

Зургаа. Санхүүжилт

6.1. Цэцэрлэг нь төсвийн төлөвлөлт хийхдээ суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсах зардлыг Засгийн газраас баталсан журмын дагуу нормативыг нэмэгдүүлж тооцно.

6.2. Цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид холбогдох дүрэм, журам, зааврын дагуу нэмэгдэл хөлс олгоно.

6.3. Сургалтын үйл ажиллагаанд зориулан ном, гарын авлага, тоног төхөөрөмж, тохирох хэрэглэгдэхүүн худалдан авах, гадна, дотно орчин, анги, танхим тохижуулахад шаардагдах хөрөнгийг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, хандив тусламжаар шийдвэрлэж болно.

-----oOo-----